



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/395

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод 2023 оны 05 дугаар сарын 21-28-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Олон улсын туршлага солилцох, хамтын ажиллагааг бэхжүүлэх” чуулга уулзалтад аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Нийгмийн ажилтан Сүрэнхорлоогийн Пүрэвдуламыг оролцуулсугай.

2.Замын зардал 1,750,000 (нэг сая долоон зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

2023 11 0760

D:My Doc. Zahiramj. Zasag darga